

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын
шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг энэхүү тогтоолын
хавсралтын дагуу “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар
хэлэлцүүлэн батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 1.1. ОРЛОГО: Компани 2025 онд түрээсийн үйл ажиллагаанаас 9,395,405,214.57 төгрөгийн орлоготой ажилласан.
- 1.2. ЗАРДАЛ: Компани 2025 онд үндсэн үйл ажиллагаандаа 8,250,094,316.36 төгрөгийн зардалтай ажилласан.
- 1.3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: Компани дээрх орлого болон зардалд үндэслэн 2025 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 1,145,310,898.21 төгрөгийн ашиг олсон байна.

2. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 2.1. БУСАД ОРЛОГО: 2025 онд Эрдэнэс таван толгой ХК-ийн ноогдол ашиг 25,411,488.00 төгрөг, Голомт банкны харилцах дансны хүүгийн орлого 3,150,093.04 төгрөг, бусад орлого 2,863,045.86 төгрөг буюу үндсэн үйл ажиллагааны бус орлогын нийт дүн 31,424,626.90 төгрөг байна.
- 2.2. БУСАД ЗАРДАЛ: Компани 2025 онд үндсэн үйл ажиллагааны бус зардал гаргаагүй, татварын зардал нь 120,894,401.01 төгрөг байна.
3. ЦЭВЭР АШИГ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2025 онд 24,747,446.36 төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлээр 1,055,841,124.10 төгрөгийн ашигтай ажилласан. Ашиг өндөр гарсан шалтгаан нь ус, дулааны тарифыг өсөлттэй төлөвлөсөн боловч тариф өсөөгүй, мөн лифтний болон гэрэлтүүлгийн засвар шинэчлэлтийн ажил хийгдээгүйгээс түүнд ноогдох ашиглалт, засвар, үйлчилгээний зардлууд гараагүйтэй холбоотой байна.
4. ДҮГНЭЛТ: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэв.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 09:30 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө хаягт байрлах “Номин юнайтед” төвийн 4.5 дугаар давхрын “Улаанбаатар” хурлын өрөөнд танхимаар болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2025 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр, 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор дамжуулан тараахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн болон цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг хурал эхлэх хүртэл хугацаагаар тасалбар болгож, брокер дилерийн компаниуд болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн

чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин юнайтед” цогцолборын 4-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр тус тус хүлээж авахаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Навааныг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Ганзоригийн Өсөхбаярыг, тооллогын комиссын гишүүдээр Хуульч Ганбаатарын Энхзаяа, Нягтлан бодогч Нямбаатарын Сүрэнжав нарыг томилсугай.
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатарыг, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН